

---

Доктор (Ph.D), МУИС-ийн профессор, Р.Дарьхүү  
МУИС-ийн Философийн тэнхмийн багш,  
Магистрант Г. Бат-Эрдэнэ

## 2.6. ХЯТАДЫН ФИЛОСОФИЙН ОРЧИН ҮЕИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

*Түлхүүр үг: Хятадын прагматизм, уламжлалт философи, Хятадын онцлогтой  
марксизм, даосист философи, Фэн Ю Ланы философи*

Философи нь ертөнцийг үзэх үзлийн нэгэн өвөрмөц хэлбэр болохын хувьд Хятадад одоогоос 3000 орчим жилийн тэртээ үүсч хөгжиж иржээ. XX зууныг хүртэл Хятадад цэвэр үндэсний философи ноёрхож байв.

Харин XX зуунд Хятадад философийн мэдлэг ухаан улам бүр өргөжин хөгжиж, мэргэжлийн бие даасан салбар болсон түүхтэй ажээ.

1915 онд Бээжин Их Сургуульд анх өрнийн философийн салбар нээсэн нь өрнийн философийг судалж, суралцах, сурталчлах эхлэлийг тавьж өгчээ. Түүнчлэн 1919 онд Ж. Дьюи, Б. Рассел нарыг Бээжин Их Сургуульд урьж лекц уншуулсан нь Хятадад ирсэн өрнийн анхны философичид байв. Мөн Хятадын засгийн газраас зориуд АНУ, Англи, Франц, Герман зэрэг улс оронд өрнийн соёл, философи, шинжлэх ухааныг судлуулахаар өөрийн философичдыг явуулж байсан гэдэг. Тухайлбал, XX зууны эхэн үед Янь Фу-г (1853-1920) Англид илгээж, тэрээр өрнийн нийгэм улс төр, оюун санааны амьдралын өөрчлөлт, хөгжлийг нүдээр үзэж, суралцжээ. Тэрээр эх орондоо буцаж ирээд, Ж. Миллийн “Логикийн систем”, “Эрх чөлөөний тухай”, Г. Спенсерийн “Социологи”, Ш.Монтескьегийн “Хуулийн дээд санаа”, Жевоны “Логикийн лекцүүд” зэрэг өрнийн олон алдартай бүтээлүүдийг Хятад хэл дээр орчуулж, бас тайлбар бичсэн буй. Мөн түүхч, археологич, зохиолч Ван Го Вэй (1877-1927) нь И. Кант, Ф. Ницше, А. Шопенгауэр, Вундт зэрэг Германы философичдын сонгодог бүтээлүүдийг орчуулж, нийтлүүлжээ.

XX зуунд Хятадад Америкийн прагматизмыг дэлгэрүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн бол нийгэм-улс төрийн зүтгэлтэн, түүхч, философич, шинэчлэгч үзэлтэн Ху Ши<sup>1</sup> (1891-1962) юм. Тэрээр 1917 онд АНУ-ын Колумбын Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан бөгөөд 1917 оноос Бээжингийн Их Сургуульд профессор, 1928 оноос Хятадын ШУА-ийн ерөнхийлөгчийн алба хашиж байсан байна. Түүний

---

<sup>1</sup> Ху Ши- Китайская философия. Энциклопедический словарь. М., 1994. с.389

зохиолуудын эмхэтгэл 4 боть нь 1925 онд Шанхайд хэвлэгджээ. Ху-Ши-гийн философийн гол бүтээлүүдээс дурьдвал, “Эртний Хятад дахь логик аргын хөгжил”, “Хятадын философийн түүхийн лекц” зэрэг болно. Эртний Хятад дахь логик аргын хөгжил бүтээлдээ Логик ба философи түүний түүхэн эх сурвалж, Күнзийн намтар логик, Мо Ди-ийн логик, прагматик арга, бодомжийн хуулиуд, индукци, дедукци, Жуанз-ийн логик, Сүнзийн логик зэргийн талаар тайлбарласан буй. Түүний үзлээр, прагматизм нь хүний амьдралын замыг заагч луужин юм. Прагматизм нь өөртөө арга зүй, үнэний онол, реалист онолыг багтааж байдаг. Түүний философийн гол үзэл санаа нь хүний сэтгэхүйг хөгжүүлэх онол, хувьсахуйн онол, нотлох онол юм. Эдгээр бүтээлээ прагматизмын онол-арга зүйн үүднээс тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, уг бүтээл нь агуулгын хувьд Хятадын философи, хэлбэрийн хувьд прагматизм болжээ. Иймд түүний бүтээлүүд нь Хятад хүний хөлөнд өрнөдийн шаахайг өмсүүлсэнтэй утга нэг болсон гэдэг. Энэ нь нэг ёсондоо Ху-Ши-гийн философи нь Хятадчилагдсан прагматизм мөн болохыг харуулж байна.

Ху-Ши нь Хятадын уламжлалт философийг өрнийн философийн агуулгаар өргөжүүлэн шинэчлэх зорилгыг дэвшүүлж, улс орноо өрнийн капитализмын замаар хөгжүүлэхийг уриалж байжээ. Түүний үзлээр, “Хятадын ард түмний хөгжил дэвшилд саад болж буй гол дайсан бол ард түмний ядуурал, бүдүүлэг байдал, үймээн самуун, хээл хахууль, элдэв төрлийн өвчин юм. Ийм дайсантай тэмцэх гол арга хэрэгсэл нь өрнийн соёл, шинжлэх ухаан, философиос суралцах явдал”<sup>1</sup> гэжээ.

Ийнхүү XX зууны эхэн үед Хятадын философийг өрнөчлөх хандлага нэлээд хүчтэй болжээ.

Мөн үүний зэрэгцээ энэхүү хандлагыг эсэргүүцсэн, уламжлалт философио цэврээр хадгалж, хөгжүүлэх гэсэн хандлага ч гарч ирсэн буй. Энэ чиглэл хандлагын хувьд Хятад улс бусдыг хуулбарлан дууриах шаардлагагүй. Хятад улс нь эртний соёл иргэншил бүхий өөрийн онцлогтой, бие даасан өөрийн замаар хөгжих ёстой гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлжээ. Энэ чиглэлийн нэг томоохон төлөөлөгч бол Лян Шу Мин<sup>2</sup> юм. Түүний үзлээр, хүн төрөлхтний соёл болон иргэншлийн түүхэнд Хятад, Энэтхэг, Европын соёл иргэншил онцгой байр эзэлдэг. Эдгээр соёл иргэншил бүхэн өөрийн давтагдашгүй онцлогтой, түүнийгээ хадгалж байх нь чухал. Хятад соёл иргэншлийн гол цөм нь Күнзийн философи, иймд Күнзийн философийн үндсэн үзэл,

<sup>1</sup> Буров.В.Г. Современная Китайская философия М., 1980. с.45

<sup>2</sup> Лян Шу Мин- Китайская философия. Энциклопедический словарь. М.,1994.

---

зарчмыг шинэ агуулгаар өргөжүүлж, шинэчлэх замаар хөгжих нь илүү зохистой хэмээн Лян Шу Мин онцолжээ. Тэрээр Хятадын философийн үнэт өв уламжлалд илүү ач холбогдол өгч байжээ. Түүний үзлээр, орчин үе бол Хятад үндэстэний сэргэн мандлын үе. Хятадын соёл иргэншлийн гол цөм нь Күнзийн сургаал мөн. Күнзийн сургаалд хүн, нийгэм, төр ямар байх ёстойг зааж өгсөн. Нийгмийн болон хүний хөгжлийн гол зүйл нь оюуны соёл болохоос эдийн засаг, улс төр гол зүйл биш хэмээн тайлбарлажээ. Хятад улс гадаад улс орныг шууд хуулбарлан дууриах биш, цэвэр өөрийнхөөрөө хөгжих ёстой гэдгийг онцолсон буй.

XX зууны Хятадын философид марксист философи нь 30-аад оноос дэлгэрч, төрийн албан ёсны философи болсон түүхтэй. Марксист философийн сонгодог бүтээлүүд болох К. Марксын "Философийн гуйланчлал", Ф. Энгельсийн "Дюрингийн эсрэг", "Байгалийн диалектик", В. И. Лениний "Материализм ба эмпириокритицизм" зэрэг олон зохиол, мөн 1950 оноос марксист философийн сурах бичгүүд Хятад хэл дээр орчуулагджээ. Үүний зэрэгцээ Хятадын марксист Чэн Ду Сю, Ли Да Жао, Ай Си Ци, Ян Хин Шун нар өөрсдийн зохиол бүтээлүүдэд марксист философийг сурталчилж, Хятадын онцлогтой марксист философийг бий болгожээ. Жишээ нь: Ли Да-гийн бичсэн "Нийгэм судлалын лекц", Ай Си Ци-гийн "Олон түмний философи" /1950/, "Диалектикийн тухай", "Түүхийн материализмын лекц ба нийгмийн хөгжлийн түүх" /1953/, Диалектик материализмын лекц /1957/ гэх мэт.

Мөн түүнчлэн 1955 онд Хятадад философийн хүрээлэн байгуулагдаж, "Философийн судалгаа" хэмээх мэргэжлийн сэтгүүл гаргаж, марксист философийг судлах, сурталчлах үйлст томоохон үүрэг гүйцэтгэжээ. 1956 онд Бүх Хятадын философичдын холбоог байгуулж, тэргүүнээр Ли Да-г сонгожээ. 1956 онд Бээжин Их сургууль, Ард түмний Их сургуульд философийн салбар нээжээ.

1958-1965 оны үед Хятадын философид Маоист философийн нөлөө байр суурь голлох болжээ. Энэ үед философийг хэт үзэл сурталжуулж, "Дорнын салхи өрнийн салхийг ялна" гэсэн уриаг дэвшүүлж, улмаар 1962-1972 онд соёлын хувьсгал гарч, маоизмыг тахин шүтэх үзэл дэлгэрчээ. Соёлын хувьсгал нь маоизмыг эсэргүүцсэн аливаа үзлийг дарах, маоист үзлийг хүчээр хэрэгжүүлэх зорилго бүхий үйл явц байв. Мао Цзе Дуны /1893-1976/ бичсэн философийн гол бүтээлүүд<sup>1</sup> нь "Шинэ ардчиллын тухай" /1940/, "Практикийн онол", "Зөрчлийн онол" /1937/ зэрэг болно. Тэрээр марксист философийн үзэлд шүүмжлэлттэй хандахын зэрэгцээ

---

<sup>1</sup> Мао Цзе Дун. Избр. Произведения. Т. I-4. М., 1952-1953

Хятадын уламжлалт философийн үндсэн үзэл баримтлалыг марксист философийн зарим үзэл санаагаар нэмэн шинэчилжээ. Тухайлбал, Мао Цзе Дун “Диалектикийн тухай” зохиолдоо: Энгельс диалектикийн гурван хуулийг ярьсан. Би түүний хоёрт нь итгэдэггүй. “Учир нь үндсэн зүй тогтол нь эсрэг тэсрэгийн нэгдэл мөн. Үгүйсгэлийн үгүйсгэлийн хууль гэж ерөөсөө байхгүй. Тоо чанар хоёр нь эсрэг тэсрэгийн нэгдэл юм”<sup>1</sup> гэжээ. Мөн “Зөрчлийн тухай” зохиолдоо тэрээр өгүүлэхдээ “Зөрчил бол аливаа нийгмийн хөдөлгөгч хүч юм. Зөрчилгүй юм гэж үгүй. Амьдрал ба үхэл, зовлон ба жаргал гэх зэргээр зөрчил бүхэн эвлэршгүй байдаг. Юмс үзэгдлийн хөгжлийн гол шалтгаан нь дотоод зөрчил байдаг”<sup>3</sup> гэжээ.

Хятадын орчин үеийн философид 1980-аад оноос гарч ирсэн нэг шинэ чиглэл хандлага нь Хятадын уламжлалт философийг өрнийн философийн онол арга зүйн үүднээс шинэчлэн боловсруулах, өөрөөр хэлбэл, Хятадын болон өрнийн философийг хослуулан судлах, сурталчилах чиглэл мөн. Ийм чиглэлийг баригчдын нэг бол ХХ зууны Хятадын нэрт философич Фэн Ю Лань ( 1895-1990 ) юм.

Фэн Ю Лань нь Шанхай Их Сургууль, Бээжин Их Сургуульд философийн чиглэлээр суралцаж төгссөн мэргэжлийн философич хүн. Тэрээр 1924 онд АНУ-д Колумбийн их сургуульд Ж.Дьюи-гийн удирдлагаар докторын зэрэг хамгаалсан бөгөөд Хятадын дэлхийд нэртэй их сургуулиуд болох Цинхуа Их сургууль, Бээжин Их Сургуульд профессор, мөн 1946-1947 онд Америкийн Пенсильваны Их Сургуульд зочин профессороор уригдан ажиллаж байсан. Хятадын шинжлэх ухааны академийн гишүүн юм.

Түүний философийн гол бүтээлүүд<sup>4</sup> нь “Шинэ рационализм” (1939) “Хятадын философийн товч түүх” (1934), “Хятадын эрх чөлөөний зам” (1939), “Хүний уг чанарын тухай шинэ шастир” (1943), “Метафизикийн тухай шастир” (1946) зэрэг болно.

Тэрээр “Шинэ рационализм” (Синь ли сюэ) зохиолдоо “Ли”, “Дао”, “Ци” зэрэг Хятадын уламжлалт философийн үндсэн ойлголтуудыг шинэ агуулгаар тайлбарласан буй. “Хятадын философийн товч түүх” ном нь АНУ, Орос зэрэг өрнийн олон оронд олон хэл дээр орчуулагдсан байна. Манайд 2003 онд уг номыг Ү.Нямдорж монгол хэл дээр хөрвүүлсэн болно. Энэхүү бүтээлдээ Фэн Ю Лань Хятадын философийн түүхийг өрнийн философийн арга зүйгээр бичсэн онцлогтой. Өөрөөр хэлбэл, Хятадын олон

<sup>1</sup> “О противоречин” – Мао Цзэ Дун. Избр. Произведения Т. I. М., 1952

<sup>3</sup> Мао Цзэ Дун – Велекие мыслители Востока. М., 1998. с.173

<sup>4</sup> Фэн Ю-Лань- Велекие мыслители. Востока. М., 1999

---

зуун жилийн цэцэн мэргэн ухааны өв санг өрнийн философийн арга зүйн үүднээс авч үзсэн юм.

Фэн Ю Лань Хятадын уламжлалт философид оюун ухааныг дээдлэх үзэл зарчим гол зарчим байдгийг онцолж, философи нь амьдралын тухай цэгцтэй, шүүн тунгаах сэтгэхүйн үйл ажиллагаа хэмээн үздэг.

Тэрээр “Хүний уг чанарын тухай шинэ шаштир”<sup>1</sup> зохиолдоо хүний амьдрал, үйл ажиллагааг дөрвөн хүрээнд авч үзжээ. Үүнд, Нэгдүгээрт, гэнэн хүрээ бол хүн өөрийн үйлдэл, үйл ажиллагааг өөрийн зөн, эсвэл нийгмийн заншилд хөтлөгдөн үйлддэг хүрээ. Хоёрдугаарт, хэрэглээний хүрээ бол өөрийгөө ухаарч, өөрийнхөө төлөө бүхнийг хийдэг аминч шинжтэй байдаг. Гуравдугаарт, зан суртахууны хүрээ бол хүн өөрийгөө нийгмийн нэг хэсэг, түүний гишүүн гэдгийгээ ойлгож, нийгмийн сайн сайхны төлөө, бусдын сайн сайхны төлөө жинхэнэ шударга, зан суртахууны үйлдэл хийдэг хүрээ. Дөрөвдүгээрт, трансцендент хүрээ бол хүн зөвхөн нийгмийн төдийгүй сансрын (“Тэнгэрийн иргэн”) бөгөөд тэрбээр юу хийлгэж буйгаа ойлгож ухамсарладаг хүний амьдралын дээд хүрээ юм. Түүний үзлээр, орчин үеийн философи нь хүнд зан суртахууны болон трансцендент хүрээнд хүрэх арга замыг зааж өгөх үүрэг, зорилготой ажээ. Өөрөөр хэлбэл, зан суртахуунт ухаалаг хүнийг төлөвшүүлэхэд философийн үүрэг ач холбогдол их гэдгийг онцолсон буй.

Түүнчлэн Фэн Ю Лань “Метафизик арга зүйн тухай шинэ шаштир” номдоо өрнийн философи нь “постулатаар гаргасан ойлголтоос” эхэлдэг бол Хятадын философи нь “интуицээр гаргасан ойлголтоос” эхэлдэг. Иймд өрнийн философид позитив арга, Хятадын философид негатив арга тус тус зонхилж байв гэж бичжээ. Иймд тэрээр өрнийн болон Хятадын философи өөр өөрийн онцлог үзэл онол, арга зүйтэй, бас харилцан бие биенээс суралцах, судлах зүйл их буйг чухалчилсан байдаг. Тэрээр Күнзийн шинэтгэсэн сургаалыг позитивист арга зүйгээр судалжээ. Ийнхүү Фэн Ю Лань Хятадын уламжлалт философийн үндсэн дээр өрнийн философийн ололтуудыг шингээн авч, өрнөчлөгдсөн Күнзийн сургаал, Күнзчлэгдсэн өрнийн философийг бий болгожээ. Фэн Ю Ланий философи нь Хятадын орчин үеийн философид хөгжлийн шинэ үеийг авчирсан гэж үзэж болно. Тэрээр Хятадын философийг өрнө дахинд таниулах, өрнийн философийг Хятадад дэлгэрүүлэхэд чухал хувь нэмрээ оруулжээ.

---

<sup>1</sup> Фэн Ю-Лань. Хятадын философийн товч түүх. УБ.2003.

---

Өмнө өгүүлсэн зүйлийг нэгтгэн хэлбэл, Хятадын орчин үеийн философийн онцлог нь нэг талаас өрнийн философи багагүй дэлгэрсэн явдал, нөгөө талаас өрнийн философи хятадчлагдах үйл явц нэлээд хүчтэй өрнөж байгаа явдалд оршино. Өөрөөр хэлбэл, Хятадын философичид нь өрнийн философийг ямар ч шүүмжлэлгүйгээр шууд хуулбарлах бус, харин уламжлалт философитой ухаалгаар хослуулан судалж, сурталчилж, суралцаж байгаа нь бидэнд ч анхаарвал зохих зүйлийн нэг мөн хэмээн бодож байна.

*Дүгнэлт*

Орчин үед Хятадын философид плюрализм дэлгэрч байна. Үүний илрэл нь Ху Ши тэргүүтэй прагматизмын чиглэл, Лян Шу Мин тэргүүтэй хятадын уламжлалт философийн чиглэл, Маоист философи, Ли Да болон Ай Си Цы тэргүүтэй марксист философи, Фэн Ю Лань тэргүүтэй постконфуцианство зэрэг олон чиглэлүүд зэрэгцэн оршиж, хөгжиж байгаа болно.

НОМ ЗҮЙ

1. Буров. В. Г. Современная Китайская философия. М., 1980
2. Великие мыслители Востока. М., 1999
3. История Китайской философии. М., 1989
4. История современной зарубежной философии. СПб. 1997
5. Китайская философия. Энциклопедический словарь. М., 1994.
6. Ломанов. А. В Интерпретация и развитие Китайской философской традиции в работах Фен Ю Ланя / 20-40 годов XX века./ М. 1993
7. Мао Цзе Дун. Избр. Произведения. Т 1-4 М. 1952-1953
8. Great thinkers of the Eastern world Edited by Ign. P.Mc Greal USA. 1995
9. Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ 2003
10. Zhongguo xiandai zhexue Beijing .2003.